ХҮҮХЭД, ЗАЛУУС, ГЭР БҮЛИЙН АСУУДЛААРХ МЭДЭЭЛЭЛ ЛАВЛАГАА

Ч.Онончимэг, Ц.Элбэгзаяа

АГУУЛГА

1. Хүн амын насны бүтэц, гэр бүлийн тоо, насны ангилал, гэр бүл дэх хүүхдийн тоо
2. Бүтэн болон хагас өнчин хүүхдийн тоо
3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо
4. Хорих газар ял эдэлж байгаа хүүхдийн тоо
5. Тэтгэлэг авдаг хүүхдийн тоо
6. Асрамжийн газар амьдардаг хүүхдийн тоо
7. Хүчирхийлэлд өртсөн хүүхдийн тоо
8. Хүүхдэд ногдох сургууль, цэцэрлэгийн тоо
9. Хүүхдийн төлөө ажилладаг байгууллагын тоо
10. Гадаад оронд үрчлэгдсэн хүүхдийн тоо, улсаар
11. Залуучуудын байгууллагад хамрагддаг залуусын тоо
12. Хот хөдөөд амьдардаг залуусын тоо
13. Залуучуудын боловсролын байдал, нас, хүйс
14. Залуучуудын гэр бүл салалтын байдал
15. Төрөөс залуучуудын талаар авах арга хэмжээний үр дүн

Манай улсын хувьд өрх, гэр бүлийн асуудлыг төрийн хэмжээнд ихээхэн анхаарч, гэр бүлийг төрөөс хамгаалах, түүний хөгжлийн таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх талаар хууль эрх зүй, бодлогын цөөнгүй баримт бичгүүдийг батлан мөрдөж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 2 дугаар бүлгийн 16 дугаар зүйлийн 11-д "... Гэрлэлт нь хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёрын тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ.

Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална" гэж заажээ. Мөн Гэр бүлийн тухай 1999 оны хуульд "Гэрлэлт гэдэг нь харилцан эрх тэгш эрх үүргийн үндсэн дээр эрэгтэй, эмэгтэй хүмүүс тодорхой ёслол, үйл ажиллагааны дүнд сайн дурын бат холбоо тогтоож хуулиар батлуулах явдал юм" гэсэн байдаг.

Гэр бүлийн байдал нь хүн ам зүйн нэг гол үзүүлэлт төдийгүй нийгмийн харилцааг зохицуулахад ач холбогдолтой юм. Судалгаанд Үндэсний статистикийн хорооноос 10 жилд нэг удаа зохион байгуулдаг "Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогын үр дүнг суурь мэдээлэл болгосон бөгөөд энэхүү тооллогын хүрээнд гарсан сэдэвчилсэн судалгааны үр дүнгийн мэдээллийг ашигласан болно.

1.1 ХҮН АМЫН НАСНЫ БҮТЭЦ, ГЭР БҮЛИЙН ТОО, НАСНЫ АНГИЛАЛ, ГЭР БҮЛ ДЭХ ХҮҮХДИЙН ТОО

2010 оны тооллогоор Монгол Улсад нийт 713780 өрх тоологдсон нь 2000 оны тооллогоос 31.9 хувиар нэмэгдсэний дотор хотын өрх 61.9 хувиар өсөж, хөдөөгийн өрх 4.3 хувиар буурсан байна. Насны бүлгийн хувьд авч үзвэл 0-24 насны 1332.3 мянган хүүхэд, залуучууд тоологдсон нь 2000 оны мөн үеийн тооллогоос 1.2 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Хүн амын насны бүтэц

Насны бүлэг	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013
0-4	235 893	216 960	232 963	247 698	263 186	276 321	346 041	305 258	319 422
5-9	273 818	243 465	246 879	240 358	233 139	228 193	222 256	231 805	248 674
10-14	322 924	276 262	269 186	262 156	253 856	248 224	237733	237 751	234 216
15-20	356 317	364 171	364 188	357 898	350 644	339 162	322 871	310 248	303 972
21-25	262 228	247 062	255 888	269 864	286370	299 136	315 466	312 752	310 663
26-31	271 359	265 616	270 887	279 436	291 279	300 400	321 709	329 883	339 879
32-39	303 041	315 650	322 013	328 172	340 841	451 087	371 706	377 857	384 064
40-49	237 098	295 893	299 356	306 450	312 198	323 874	329 426	336 152	342 881
50-55	101 172	144 199	147 330	156 566	165 406	174 105	181 262	191 937	202 616
56-60	58 456	64 916	64 307	67 374	69 034	72 772	73 233	81 596	87 313
61-69	76 407	84 772	83 183	84 264	83 967	88 721	81 202	81 542	85 449
70+	52 368	64 286	64 266	65 719	66 055	67 742	67 673	70 963	71 128
БҮГД	**2551081**	**2583254**	**2620446**	**2665955**	**2716275**	**2760968**	**2811666**	**2867744**	**2930277**

Эх сурвалж: УСХ-ны www.1212.mn мэдээллийн сан. ID хүснэгтийн дугаар: DT_NSO_0300_062V1

Хүснэгт 2. Гэр бүл, өрхийн тоо, өрхийн хэлбэрээр
/2010 оны улсын тооллогын дүнгээр/

	Өрхийн хэлбэр									
	Бүгд		Ганц бие		Ам бүлээрээ[290]		Нийлмэл ам бүл[291]		Холимог ам бүл[292]	
	Өрх	Хүн ам	Өрх	Хүн ам	Өрх	Хүн ам	Өрх	Хүн ам	Өрх	Хүн ам
Бүгд	713780	2553753	75917	75917	445048	1594314	177898	815639	14917	67883
Хот	479503	1734761	47246	47246	275599	960251	145323	674653	11426	52611
Хөдөө	234277	818992	28671	28671	169449	634063	32666	140986	3491	15272

Эх сурвалж: Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогын дүн

[290]Ам бүлээрээ өрх гэдэг нь ам бүлээрээ байгаа өрх дангаараа амьдрахыг хэлнэ. Өөрөөр хэлбэл эхнэр, нөхөр, хүүхдийн /хүүхдүүдийн/ хамт, мөн эцэг эсвэл эх нь хүүхдийн /хүүхдүүдийн/ хамт өрх үүсгэн амьдрахыг хэлнэ.
[291]Нийлмэл ам бүлтэй өрх гэдэг нь нэг ам бүл бусад хамаатан, садантайгаа, эсхүл хоёр түүнээс дээш хоорондоо хамааралтай ам бүл хамтран өрх үүсгэн амьдарч байгааг ойлгоно.
[292]Холимог өрх гэдэг нь дараах бүтэцтэй өрх хамаарна.

- Нэг ам бүл бусад хамаатан, садан эсхүл хамааралгүй хүмүүстэй хамтран өрх үүсгэн амьдарч байгаа өрх,
- Нэг ам бүл, хамааралгүй хүмүүстэй хат өрх үүсгэн амьдарч байгаа өрх,
- Хоёр, түүнээс дээш хоорондоо хамааралтай ам бүл, аль нэгнийх нь хамаатан, садан, хамааралгүй хүмүүстэй хамтран өрх үүсгэн амьдарч байгаа,
- Хоорондоо хамааралгүй боловч ам бүлийн биш хоёр, түүнээс олон хүмүүс бусад хамааралгүй хүмүүстэй өрх үүсгэн хамтран амьдарч байгаа.

Тоологдсон нийт 713 780 өрхийн 75 917 өрх нь ганц бие, 177 898 нийлмэл өрх, 445 048 ам бүлээрээ амьдарч байгаа өрх, 14 917 өрх нь холимог хэлбэрээр амьдарч байна. 2000 онд явуулж байсан тооллогоор нийлмэл буюу эцэг эх, ах дүүс, садан төрлөөрөө хамт амьдарч байгаа өрхийн тоо хотод хөдөөнөөс 2 дахин их байсан бол 2010 оны байдлаар 4.4 дахин их болсон байна.

Нийлмэл өрхийн нийт өрхөд эзлэх хувь хотод хөдөөнөөс 2 дахин их байна. Энэ нь хөдөө орон нутгаас хотод суралцах болон бусад шалтгаанаар хотод хамаатан, садныхаа айлд амьдрах, айл бүр тусдаа орон сууцтай болж чадахгүй байгаа зэрэг шалтгаантай холбоотой юм.

Улсын хэмжээнд өрхөд тоологдсон хүн амын тоо 2 553.8 мянган, өрхийн тоо 713.8 мянга байгаа бөгөөд нэг өрхөд дунджаар 3.6 хүн ногдож байна. Нийт хүн амын 67.9 хувийг хотын хүн ам эзлэж байгаа бөгөөд энэ нь хотод суугчдын тоо хөдөөнийхөөс 2.12 дахин, өрхийн тоо 2.05 дахин их байна.

Хүснэгт 3. Өрхийн тоо болон 16 хүртэлх насны хүүхдийн тоо

	Нийт өрхийн тоо	***16 хүртлэх насны* хүүхэдтэй өрхийн тоо**	**Хувь**
Бүгд	713 780	446 690	62.6
Хот	479 503	295 665	61.7
Хөдөө	234 277	151 025	64.5

Манай улсын 0-18 насны хүүхэдтэй өрхийн 80 гаруй хувь нь 0-15 насны хүүхэдтэй өрх байна. Улсын хэмжээнд 713.8 мянган өрхийн 446.7 мянга буюу 62.6 хувь нь 16 хүртэлх насны хүүхэдтэй өрх байна. Хүүхэдтэй 5 өрх тутмын 4 нь нэг эсхүл хоёр хүүхэдтэй байгаа бөгөөд нийт хүүхдийн тоог тооцож үзвэл нэг өрх дунджаар 1.8 байна.

Хүснэгт 4. Хүүхэдтэй өрх, тухайн өрхөд амьдарч байгаа хүүхдийн тоо

	Өрхийн тоо	***6 хүртлэх насны хүүхэдтэй***		***7-17 хүртлэх насны хүүхэдтэй***		***18-24 хүртлэх насны залуучуудтай***	
		Өрхийн тоо	Хүүхдийн тоо	Өрхийн тоо	Хүүхдийн тоо	Өрхийн тоо	Залуучуудын тоо
Бүгд	475 265	283 787	372 548	392 987	505 400	247 649	357 591

1.2 БҮТЭН БОЛОН ХАГАС ӨНЧИН ХҮҮХДИЙН ТОО

Хүснэгт 5. Хагас өнчин хүүхдийн тоо

Бүс	***2008 он***	***2009 он***	***2010 он***	***2011 он***	***2012 он***	***2013 он***
УЛСЫН ДҮН	**43 088**	**41 174**	**38 248**	**36 465**	**36 143**	**35 461**
Баруун бүс	9 704	9 453	8 288	7 975	7 378	7 279
Хангайн бүс	10 802	10 190	9 777	9 277	9 541	8 920
Төвийн бүс	6 884	6 804	5 969	5 804	5 518	5 263
Зүүн бүс	3 544	3 235	2 921	2 725	2 680	2 464
Улаанбаатар	12 154	11 492	11 293	10 684	11 026	11 535

Эх сурвалж: УСХ-ны www.1212.mn мэдээллийн сан. ID хүснэгтийн дугаар: DT_NSO_0300_008V1

Хүснэгт 6. Бүтэн өнчин хүүхдийн тоо

Бүс	*2008 он*	*2009 он*	*2010 он*	*2011 он*	*2012 он*	*2013 он*
УЛСЫН ДҮН	**5 018**	**4 683**	**4 666**	**4 311**	**4 288**	**4 096**
Баруун бүс	871	869	853	763	713	670
Хангайн бүс	1 220	1 101	1 045	919	915	872
Төвийн бүс	801	755	696	641	585	553
Зүүн бүс	397	350	331	326	282	261
Улаанбаатар	1 729	1 608	1 741	1 662	1 793	1 740

Эх сурвалж: УСХ-ны www.1212.mn мэдээллийн сан. ID хүснэгтийн дугаар: DT_NSO_0300_007V1

1.3 ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН ТОО

Монгол Улсын хэмжээнд 15 хүртлэх насны нийт хүүхдийн 1.3 хувь нь буюу 9.5 мянган хүүхэд хөгжлийн бэрхшээлтэй байна. Монгол Улсын Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуульд зааснаар “Бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согогийн улмаас бусдын адил нийгмийн харилцаанд оролцох чадвар нь бүрэн болон 12 сараас дээш хугацаагаар хязгаарлагдсан хүнийг хөгжлийн бэрхшээлтэй” гэж тооцдог.

Хүснэгт 7. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо

Насны бүлэг	*Бүгд*		*Төрөлхийн бэрхшээлтэй*		*Хөгжлийн олдмол бэрхшээлтэй*	
	Тоо	*Хувь*	*Тоо*	*Хувь*	*Тоо*	*Хувь*
БҮГД	9461	100	6273	66.3	3188	33.7
0-4	1957	20.7	1436	73.4	521	26.6
5-9	3068	32.4	2106	68.8	962	31.2
10-14	4436	46.9	2731	61.6	1705	38.4

Насны хувьд төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 77.1 хувийг 5-14 насны, хөгжлийн олдмол бэрхшээлтэй хүүхдийн 53.5 хувийг 10-14 насны хүүхдүүд эзэлж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн 29 хувь нь хөдөлгөөний бэрхшээлтэй, 20 хувь нь харааны, 13 хувь нь ярианы, 8 хувь нь сонсголын, 17 хувь нь сэтгэцийн, 13 хувь нь бусад төрлийн хөгжлийн бэрхшээлтэй байна.

1.4 ХОРИХ ГАЗАР ЯЛ ЭДЭЛЖ БАЙГАА ХҮҮХДИЙН ТОО

Хүснэгт 8. Гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон, хорих ял авсан
18 наснаас доош хүүхдийн тоо, хоригдсон дундаж хоногийн тоо

Он	*Хүүхдийн тоо*	*Хоригдсон хугацаа*
2009	129	Дунджаар 3 сараас 2 жил 6 сар
2010	48	Дунджаар 3 сараас 2 жил 6 сар
2011	72	Дунджаар 3 сараас 2 жил 6 сар
2012	81	Дунджаар 3 сараас 2 жил 6 сар
2013	79	Дунджаар 3 сараас 2 жил 6 сар

Эх сурвалж: ХТҮГ-ын Халамжийн үйлчилгээний бүртгэлийн нэгдсэн систем

1.5 ТЭТГЭЛЭГ АВДАГ ХҮҮХДИЙН ТОО

Хүснэгт 9. Шийдвэр гүйцэтгэх газрын хүүхдийн тэтгэлгийн бодит биелэлтийн харьцуулалт

Д/д	Шийдвэр гүйцэтгэх алба		2010 он		2011 он		2012 он		2013 он		2014 он	
			Биелүүлбэл зохих	Бодит биелүүлсэн	Биелүүлбэл зохих	Бодит биелүүлсэн	Биелүүлбэл зохих	Бодит биелүүлсэн	Биелүүлбэл зохих	Бодит биелүүлсэн	Биелүүлбэл зохих	Бодит биелүүлсэн
1	Архангай	гүйцэтгэх хуудас	184	42	163	9	204	30	193	31	187	27
		мөнгөн дүн	113094.4	107096.0	70998.0	43882.0	103049.3	53515.4	164870.4	68150.5	170607.1	49240.0
2	Баян-Өлгий	гүйцэтгэх хуудас	64	0	77	17	74	7	79	12	72	5
		мөнгөн дүн	5611.8	4958.3	11219.6	10554.0	22139.0	21539.4	9787.0	9787.0	25015.4	25015.4
3	Баянхонгор	гүйцэтгэх хуудас	452	26	484	26	495	74	449	117	353	99
		мөнгөн дүн	80955.2	75539.5	87010.9	81358.2	93161.0	71070.0	95091.0	65000.0	30091.0	18000.0
4	Булган	гүйцэтгэх хуудас	286	17	289	37	277	39	250	42	234	41
		мөнгөн дүн	31500.0	31500.0	35255.5	35255.5	48012.9	48012.9	65568.5	65568.5	45244.8	45244.8
5	Говь-Алтай	гүйцэтгэх хуудас	140	30	137	20	142	19	142	19	137	16
		мөнгөн дүн	89744.6	59020.9	78592.4	54195.6	82665.3	60199.5	82947.3	61984.5	73157.0	51083.1
6	Говьсүмбэр	гүйцэтгэх хуудас	170	16	159	20	157	15	154	17	190	21
		мөнгөн дүн	62792.6	43300.0	39900.9	28296.6	35725.3	6235.1	16990.0	16990.0	28670.0	28670.0
7	Дархан-Уул	гүйцэтгэх хуудас	470	44	446	34	472	25	517	29	521	35
		мөнгөн дүн	72988.8	72988.8	88064.4	88064.4	115900.6	115900.6	136616.1	136616.1	130262.8	130262.8
8	Дорноговь	гүйцэтгэх хуудас	461	52	454	27	474	16	552	64	260	25
		мөнгөн дүн	275521.4	75250.0	219356.3	99507.6	151104.0	90295.6	469068.6	159482.3	311725.2	84788.4
9	Замын-Үүд	гүйцэтгэх хуудас	-	-	-	-	-	-	-	-	184	37
		мөнгөн дүн	-	-	-	-	-	-	-	-	99547.6	59230.3

10	Дорнод	гүйцэтгэх хуудас	408	48	394	56	369	46	349	66	273	43
		мөнгөн дүн	61363.0	60223.1	63560.7	63203.5	87145.2	87145.2	99227.7	99227.7	65370.5	65370.5
11	Дундговь	гүйцэтгэх хуудас	245	34	238	21	241	26	233	26	224	22
		мөнгөн дүн	180214.5	68378.4	139315.0	88071.7	109894.9	67860.7	132841.2	83406.7	101366.7	57100.8
12	Завхан	гүйцэтгэх хуудас	139	14	143	16	162	21	159	22	108	16
		мөнгөн дүн	56600.2	48441.8	48249.9	42311.6	43690.7	39895.7	88066.3	87554.7	84822.1	77295.9
13	Төсөнцэнгэл	гүйцэтгэх хуудас	-	-	-	-	-	-	-	-	46	4
		мөнгөн дүн	-	-	-	-	-	-	-	-	12451.8	12451.8
14	Орхон	гүйцэтгэх хуудас	885	102	902	247	818	88	790	106	741	59
		мөнгөн дүн	215790.8	174857.3	266130.7	228795.8	246518.2	216463.0	312717.2	278031.9	351476.4	274650.5
15	Өверхангай	гүйцэтгэх хуудас	243	34	251	20	259	31	259	46	251	34
		мөнгөн дүн	51089.3	43163.1	44618.7	37287.9	45519.3	43318.9	72465.0	72465.0	56761.0	56761.0
16	Өмнөговь	гүйцэтгэх хуудас	351	46	366	65	339	93	286	44	243	27
		мөнгөн дүн	72881.0	72881.0	113915.0	113915.0	149334.0	149334.0	154717.0	154717.0	102332.0	102332.0
17	Сүхбаатар	гүйцэтгэх хуудас	235	9	259	20	269	20	291	41	271	16
		мөнгөн дүн	50432.0	33606.4	81051.6	60025.4	85584.8	75849.2	108316.9	80752.3	53291.8	21410.2
18	Сэлэнгэ	гүйцэтгэх хуудас	415	25	445	10	527	96	458	69	326	22
		мөнгөн дүн	114365.7	45749.8	87126.0	38204.2	103724.0	50862.7	41790.4	27516.6	1886.7	1886.7
19	Хэнтэл	гүйцэтгэх хуудас	-	-	-	-	-	-	-	-	88.0	7.0
		мөнгөн дүн	-	-	-	-	-	-	-	-	79083.6	33130.7
20	Төв	гүйцэтгэх хуудас	298	38	303	30	310	52	311	42	201	24
		мөнгөн дүн	69987.3	63646.2	116851.8	108448.6	137889.3	131072.4	158509.4	148676.9	80392.9	52371.8
21	Увс	гүйцэтгэх хуудас	130	17	122	17	123	12	124	24	117	20
		мөнгөн дүн	18581.2	17435.7	16788.0	15441.6	26166.7	21341.8	26438.1	22570.1	28977.6	16611.4
22	Ховд	гүйцэтгэх хуудас	112	23	126	35	122	28	134	21	123	28
		мөнгөн дүн	52028.8	45771.2	95498.7	90660.3	71589.4	67996.1	125797.9	119244.5	99223.4	91312.0

23	Хевсгэл	гүйцэтгэх хуудас	401	72	295	53	325	54	328	84	301	57
		мөнгөн дүн	107633.2	107471.6	146501.8	145411.6	206580.8	206477.5	196423.9	196423.9	133738.9	133738.9
24	Хэнтий	гүйцэтгэх хуудас	286	21	296	17	304	38	306	37	292	29
		мөнгөн дүн	24317.7	24317.7	58858.5	58858.5	93218.2	93218.2	136251.7	136251.7	99287.6	99287.6
25	НШГАлба / Налайх	гүйцэтгэх хуудас	3786	456	3919	399	3930	533	-	-	166	11
		мөнгөн дүн	550669.8	550669.8	732594.7	732594.7	751560.0	751560.0	-	-	39388.2	39388.2
26	Багануур	гүйцэтгэх хуудас	226	38	207	25	194	32	193	21	199	15
		мөнгөн дүн	59348.2	58202.9	82349.9	68416.4	112930.6	112930.6	118748.1	118748.1	117657.6	94729.1
27	Хархорин	гүйцэтгэх хуудас	182	7	188	11	186	3	200	44	177	25
		мөнгөн дүн	11674.9	10539.2	6923.4	6425.9	7150.2	6750.2	12689.2	12289.2	40425.0	40425.0
28	Мандал	гүйцэтгэх хуудас	202	18	205	27	208	11	266	52	248	16
		мөнгөн дүн	51840.0	16461.0	41049.0	7290.0	17758.9	9786.2	15330.8	12722.9	9492.3	6916.2
29	БХЗХТБААлба	гүйцэтгэх хуудас	-	-	-	-	-	-	4325.0	568.0	3097	462
		мөнгөн дүн	-	-	-	-	-	-	2336409.1	2336409.1	2100616.0	2100616.0
ДҮН		гүйцэтгэх хуудас	**10771**	**1229**	**10868**	**1259**	**10981**	**1409**	**11348**	**1644**	**9630**	**1243**
		мөнгөн дүн	**2481026.4**	**1911469.7**	**2771781.4**	**2346476.6**	**2948012.6**	**2598630.9**	**4570587.2**	**4570587.2**	**4572363.0**	**3869321.1**

1.6 АСРАМЖИЙН ГАЗАР АМЬДАРДАГ ХҮҮХДИЙН ТОО

Хүснэгт 10. Төрийн хүүхэд асрамжийн байгууллагад асруулж буй хүүхдийн тоо

Он	*2009*	*2010*	*2011*	*2012*	*2013*
Хүүхдийн тоо	-	-	-	412	439

Эх сурвалж ХТҮГ-ын Халамжийн үйлчилгээний бүртгэлийн нэгдсэн систем

Хүснэгт 11. Төрийн хүүхэд асрамжийн байгууллагын тоо

Он	*2009*	*2010*	*2011*	*2012*	*2013*
Байгууллагын тоо	-	-	-	6	6

Хүснэгт 12. Олон улсын байгууллага, гадаадын хөрөнгө оруулалттай хүүхдийн асрамжийн газарт асруулж буй хүүхдийн тоо

Он	*2009*	*2010*	*2011*	*2012*	*2013*
Хүүхлийн тоо	-	-	-	597	578

Эх сурвалж: ХТҮГ-ын Халамжийн үйлчилгээний бүртгэлийн нэгдсэн систем

Хүснэгт 13. Олон улсын байгууллага, гадаадын хөрөнгө оруулалттай хүүхдийн асрамжийн газар

Он	*2009*	*2010*	*2011*	*2012*	*2013*
Байгууллагын тоо	-	-	-	20	17

Эх сурвалж:ХТҮГ-ын Халамжийн үйлчилгээний бүртгэлийн нэгдсэн систем

Хүснэгт 14. Төрийн бус байгууллагын хүүхдийн асрамжийн газар

Он	*2009*	*2010*	*2011*	*2012*	*2013*
Байгууллагын тоо	-	-	-	5	5

Эх сурвалж: ХТҮГ-ын Халамжийн үйлчилгээний бүртгэлийн нэгдсэн систем

1.7 ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТСӨН ХҮҮХДИЙН ТОО

Хүснэгт 15. Хүчирхийлэлд өртсөн хүүхдийн тоо

Шалтгаан нөхцөл	*2009*	*2010*	*2011*	*2012*	*2013*
Эцэг, эх асран хамгаалагчдын зүгээс хүчирхийлэл, үл хайхрах байдалд өртсөн хүүхдийн тоо	95	12	24	23	24
Бэлгийн мөлжлөг, бэлгийн хүчирхийлэл, хүүхдийн наймаа, хүүхдийн хулгай хүүхдийн тоо	78	12	60	34	36

Эх сурвалж: ХТҮГ-ын Халамжийн үйлчилгээний бүртгэлийн нэгдсэн систем

Хүснэгт 16. Гэрээсээ дайжсан хүүхдийн тоо

	2009	*2010*	*2011*	*2012*	*2013*
Гэр, гэр бүлээсээ дайжсан хүүхдийн тоо /давхардсан тоогоор/	881	865	945	662	529

Эх сурвалж: ХТҮГ-ын Халамжийн үйлчилгээний бүртгэлийн нэгдсэн систем

Хүснэгт 17. Хүүхэд, ёс суртахууны эсрэг гэмт хэргийн *хохирогч* хүүхдийн тоо

	2009	*2010*	*2011*	*2012*	*2013*
Эцэг, эх асран хамгаалагчдын зүгээс хүчирхийлэл, үл хайхрах байдалд өртсөн	95	12	24	23	24

1.8 ХҮҮХДЭД НОГДОХ СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГИЙН ТОО

Манай улсын 6-14 насны 409.7 мянган хүүхэд тоологдсоны 247.0 мянган хүүхэд буюу 60.3 хувь нь боловсролгүй байгаа бөгөөд эдгээр хүүхдүүдийн 90.5 хувь нь боловсролгүй ч бичиг үсэг мэддэг байна. 2-39 насны 1834.9 мянган хүн тоологдсоны 45.6 хувь нь цэцэрлэг, сургууль хамрагдаж, 54.4 хувь нь аль нэг шатны сургуульд хамрагддаггүй байна.

Хүн амын 2-5 насны 202.4 мянган хүүхдийн 60.1 хувь нь цэцэрлэгт хүмүүжиж байгаа бол үлдсэн 39.9 хувь нь цэцэрлэгт хүмүүждэггүй байна. Нийт хүүхдийн 68.0 хувь нь хотод, 32.0 хувь нь хөдөө амьдардаг бөгөөд нийт цэцэрлэгт хамрагдсан хүүхдүүдийн 71.7 хувь нь хотод амьдардаг байна.

Хүснэгт 18. 2-5 насны хүүхдийн цэцэрлэгт хүмүүждэг эсэх

Нас	*Бүгд*			*Цэцэрлэгт хүмүүждэг*			*Цэцэрлэгт хүмүүждэггүй*		
	Бүгд	*Эр*	*Эм*	*Бүгд*	*Эр*	*Эм*	*Бүгд*	*Эр*	*Эм*
Бүгд	**202420**	**102986**	**99434**	**121647**	**60910**	**60737**	**80773**	**42076**	**38697**
2	61433	31142	30291	27361	13683	13678	34072	17459	16613
3	52128	26501	25627	30875	15369	15509	21253	11132	10121
4	45509	23177	22332	30703	15358	15345	14806	7819	6987
5	43350	22166	21184	32708	16500	16208	10642	5666	4976

6-39 насны 1632.4 мянган хүн тоологдсоны 43.8 хувь нь аль нэг шатны сургуульд суралдцаг хүмүүс байна. Сургуульд суралцдаг хүмүүсийн 48.3 хувь нь эрэгтэй, 51.7 хувь нь эмэгтэй байна. Сургуульд суралцдаг 6-14 насны хүүхдүүдийн хувьд хүйсийн ялгаа байхгүй байна.

Хүснэгт 19. Цэцэрлэгийн тоо болон цэцэрлэгийн хүүхдийн тоо, СӨБ багшийн тоо[293]

Он	*Цэцэрлэгийн хүүхдийн тоо*		*Цэцэрлэгийн тоо*		*Сургуулийн өмнөх багшийн тоо*	
	Улсын дүн	*Үүнээс Улаанбаатарт*	*Улсын дүн*	*Үүнээс Улаанбаатарт*	*Улсын дүн*	*Үүнээс Улаанбаатарт*
2008	102.5	41.1	783	237	4 242	1 700
2009	109.5	44.8	814	256	4 465	1 795
2010	122.1	54.2	839	292	4 651	1 958
2011	133.4	60.2	879	326	4 907	2 025
2012	150.2	68.6	945	368	5 332	2 177
2013	167.9	78.2	1 067	454	5 895	2 526

[293]Эх сурвалж: УСХ-ны www.1212.mn мэдээллийн сан. ID хүснэгтийн дугаар: DT_NSO_2001_010V1

Хүснэгт 20. Сургуульд суралцдаг хүүхдийн тоо

Нас	Улсын дүн		Хот		Хөдөө	
	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй
6	20 003	19 459	12 790	12 339	7 213	7 120
7	21 231	20 439	13 284	12 775	7 947	7 664
8	21 592	20 877	13 209	12 855	8 383	8 022
9	22 351	21 942	13 726	13 434	8 625	8 508
10-14	114 838	113 992	70 167	70 194	44 671	43 798

7 настай хүүхдүүдийн сургуульд хамрагдалт огцом нэмэгдсэн нь манай улсын боловсролын салбарт шинэчлэл хийж, 12 жилийн боловсрол эзэмшүүлэх шинэ тогтолцооны дагуу хүүхдийг 6 настайгаас нь сургуульд элсүүлэх болсонтой холбоотой.

Хүснэгт 21. Сургууль болон багшийн тоо

Он	Сургуулийн тоо		Сургуулийн багшийн тоо	
	Улсын дүн	Үүнээс Улаанбаатарт	Улсын дүн	Үүнээс Улаанбаатарт
2008	748	207	25 543	8 821
2009	755	209	26 070	9 126
2010	751	207	26 358	9 276
2011	752	210	26 492	9 359
2012	755	211	26 863	9 588
2013	756	208	27 204	9 952

1.9 ХҮҮХДИЙН ТӨЛӨӨ АЖИЛЛАДАГ БАЙГУУЛЛАГЫН ТОО

Хүүхдийн хөгжил, хамгаалал, оролцооны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудыг ордон, төвүүд болон идэвхитэй үйл ажиллагаа явуулж буй төрийн бус байгууллагууд гэсэн хоёр байгууллагаар гаргасан болно.

Хүснэгт 22. Ордон, төвүүд

Он	2009	2010	2011	2012	2013
Байгууллагын тоо	38	38	72	40	46

Хүснэгт 23. Төрийн бус байгууллага

Он	2009	2010	2011	2012	2013
Байгууллагын тоо	38	38	72	40	46

1.10 ГАДААД ОРОНД ҮРЧЛЭГДСЭН ХҮҮХДИЙН ТОО, УЛСААР

Хүснэгт 24. Үрчлүүлсэн хүүхдийн тоо

Насны бүлэг	2008	2009	2010	2011	2012	2013
Бүгд	2 406	2 167	2 487	2 093	1 701	1 845
3 нас хүртэлх	939	921	915	1 102	984	990
3-6	710	505	596	443	269	338

7-9	426	288	357	229	147	152
10 ба дээш	426	453	619	319	301	365

Хүснэгт 25. Үрчлэгдсэн хүүхдийн тоо /улсаар/

Насны бүлэг	*2008*	*2009*	*2010*	*2011*	*2012*	*2013*	*Өмнөх*	*Нийт*
АНУ	15	5	3	-	3	3	123	**152**
Герман	5	-	4	2	5	-	13	**29**
Канад	-	-	-	-	-	-	3	**3**
Голланд	2	-	-	-	-	-	3	**5**
Австрали	-	-	-	-	-	-	3	**3**
Япон	-	-	1	-	-	-	1	**2**
Илтали	2	-	1	3	2	2	3	**13**
Солонгос	1	-	-	-	-	-	5	**6**
Англи	-	-	-	1	-	-	3	**4**
Бельги	-	-	1	-	-	-	3	**4**
Дани	-	-	-	-	-	-	1	**1**
Финланд	-	-	-	1	-	-	-	**1**
Франц	4	3	1	2	-	-	9	**19**
Испани	-	-	-	-	-	-	1	**1**
Нидерланд	-	-	-	-	1	-	-	**1**
НИЙТ	**29**	**8**	**11**	**9**	**11**	**5**	**171**	**244**

Манай улс 2008-2013 онд нийтдээ 244 хүүхдийг гадаадын улс орнуудад үрчлүүлснээс 152 хүүхдийг АНУ-д, 29 хүүхдийг Герман улсад, 19 хүүхдийг Франц улсад, 13 хүүхдийг Итали улсын иргэдэд үрчлүүлсэн байна.

1.11 ЗАЛУУЧУУДЫН БАЙГУУЛЛАГАД ХАМРАГДДАГ ЗАЛУУСЫН ТОО

Энэ асуудлаар Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамнаас мэдээлэл хүссэн боловч манай улсын залуучуудын байгууллагууд болон тус байгууллагад хамрагддаг залуусын талаар нэгдсэн тоо мэдээлэл гардаггүй гэсэн хариултыг өгсөн.

1.12 ХОТ ХӨДӨӨД АМЬДАРДАГ ЗАЛУУСЫН ТОО

Он	*2009*	*2010*	*2011*	*2012*	*2013*
Хот	-	-	435399	429065	456345
Хөдөө	-	-	529163	518762	459972

Эх сурвалж: Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам

1.13 ЗАЛУУЧУУДЫН БОЛОВСРОЛЫН БАЙДАЛ, НАС, ХҮЙС

Улсын хэмжээнд 15-24 насны нийт залуучуудын 3.7 хувь нь ямар нэг боловсролгүй байгаа хэдий ч эдгээр залуучуудын 58.9 хувь нь бичиг үсэг мэддэг байна. 15 настангуудын 93.0 хувь, 16-19 насны 75.9 хувь, 20-24 насны 29.8 хувь нь сургуульд хамрагдаж байна.

№	Боловсролын байдал	2010 он
1	Доктор	435
2	Магистр	13785
3	Дипломын болон бакалаврын дээд	216975
4	Тусгай мэргэжлийн дунд	24044
5	Техникийн болон мэргэжлийн дунд	19648
6	Бүрэн дунд	398112
7	суурь	132560
8	бага	70977

Эх сурвалж: Хүн ам, орон сууцны 2010 оны тооллого

Хүснэгт 26. 15-24 насны залуучуудын боловсролын байдал */хувиар/*

Насны бүлэг	Бүгд			Хот			Хөдөө		
	Бүгд	Эр	Эм	Бүгд	Эр	Эм	Бүгд	Эр	Эм
15	93.0	90.5	95.6	95.8	94.7	96.9	88.2	83.5	93.1
16-19	75.9	69.6	82.5	82.9	78.9	86.8	54.4	45.2	66.8
20-24	29.8	25.8	33.8	37.3	33.5	40.9	6.2	5.1	7.6

1.14 ЗАЛУУЧУУДЫН ГЭР БҮЛ САЛАЛТЫН БАЙДАЛ

2006 оны Улсын Их Хурлын сонгуульд шинээр гэр бүл бологсод 500 мянган төгрөгийн тэтгэмжийг төрөөс нэг удаа олгох амлалтын дагуу 2011 он хүртэл шинээр гэр бүл бологсод, нийт болон шинээр төрсөн хүүхдэд мөнгөн тусламж, тэтгэмжийгбагш олгосоноор 2006-2009 оны гэрлэлтийн тооны өсөлтөнд мэдэгдэхүйц нөлөөлсөн байна.

Хүснэгт 27. Гэрлэлтийн байдал

Гэр бүлийн байдал	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013
НИЙТ	**14 711**	**48 996**	**40 965**	**32 982**	**34 071**	**9 349**	**11 869**	**12 822**	**15 785**
Баруун бүс	2 294	6 871	5 416	3 648	3 685	1 424	1 953	2 299	3 047
Хангайн бүс	3 689	11 833	9 188	6 097	6 221	2 003	2 075	2 133	2 683
Төвийн бүс	3 842	9 651	6 800	5 166	5 477	1 316	1 684	1 886	2 271
Зүүн бүс	1 137	4 374	3 018	2 198	2 351	673	879	880	1 048
Улаанбаатар хот	3 749	16 267	16 543	15 873	16 337	3 933	5 278	5 624	6 736

Эх сурвалж: УСХ-ны www.1212.mn мэдээллийн сан. ID хүснэгтийн дугаар: DT_NSO_0300_018V1

Дээрх хүснэгтээс харахад 2006 оноос эхлэн гэрлэлтийн тоо эрс нэмэгдсэн бол 2010 оноос эргээд буурсан байна. Энэ өсөлт нь дээр дурьдсан тэтгэмжүүдтэй холбоотой бөгөөд харин 2010 оноос энэхүү тэтгэмжийг өгөхөө больсонтой холбоотойгоор буурсан байна. Энэхүү 2006-2010 оны гэрлэлтийн тоо өссөнтэй холбоотойгоор гэр бүл цуцлалтын тооны өсөлт шууд хамааралтай юм.

Хүснэгт 28. Гэрлэлт цуцлалт

Гэр бүлийн байдал	*2005*	*2006*	*2007*	*2008*	*2009*	*2010*	*2011*	*2012*	*2013*
НИЙТ	**1 622**	**1 448**	**1 757**	**1 901**	**2 399**	**3 054**	**3 222**	**2 467**	**3 522**
Баруун бүс	68	51	53	65	103	147	177	86	187
Хангайн бүс	156	155	267	284	401	590	561	360	608
Төвийн бүс	252	117	243	241	326	463	483	388	516
Зүүн бүс	76	61	68	71	139	223	216	112	157
Улаанбаатар хот	1 070	1 064	1 126	1 240	1 430	1 631	1 785	1 521	2 054

Эх сурвалж: УСХ-ны www.1212.mn мэдээллийн сан. ID хүснэгтийн дугаар: DT_NSO_0300_018V1

Гэр бүл цуцлалт болон гэрлэлтийг насны ангилалаар авч үзвэл:

Нийт хүн амын 69.2 хувь /1905969/ арван тав, түүнээс дээш насны хүн ам байна. Эдгээр хүмүүсийн 31.3 хувь нь огт гэр бүл болоогүй, 60.1 хувь нь гэр бүлтэй /батлуулсан болон батлуулаагүй/, 3.1 хувь нь салсан /гэр бүлээ цуцлуулсан болон тусгаарласан/, 5.5 хувь нь бэлэвсэн байна.

Нөхөн үржихүйн насны хүн амын гэр бүлийн байдлын тархалтын хувьд огт гэр бүл болоогүй хүн ам нөхөн үржихүйн насны эхний бүлэг буюу 15-19 насны хүн амын 97.6 хувь, 20-24 насны хүн амын 64.8 хувь, 25-29 насны хүн амын 28 хувийг эзэлж байна. Дараагийн насны бүлгүүдийн хувьд харьцангуй буурсан байна.

Харин гэр бүл цуцлуулсан буюу тусгаарласан хүн ам 40-44 насныханд 6.2 хувь, 45-49 насныханд 6.3 хувь буюу хамгийн их байна.

1.15 ТӨРӨӨС ЗАЛУУЧУУДЫН ТАЛААР АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ҮР ДҮН

Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамнаас Залуучуудын хөгжлийн чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээний үр дүнгийн талаар Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамнаас 2014.08.19-ны 1/1607 тоот албан бичгээр ирүүлсэн мэдээллээс авсан болно. Монгол Улсын Засгийн үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт залуучуудын хөгжлийн асуудлаар 2 зорилт туссан. Үүнд:

- “Монгол залуу хүн” Үндэсний хөтөлбөрийн төслийг боловсруулна. /ЗГҮАХ-300.1/ - Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам нь Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах цогц бодлогыг шинэчлэн боловсруулж УИХ-д өргөн барихад бэлэн болоод байгаа юм. Энэхүү бодлогыг даган Монгол Улсын төрөөс залуучуудын хөгжлийн талаар баримтлах бодлогыг боловсруулахаар төлөвлөн ажиллаж байна. Цогц бодлого боловсруулах хүрээнд тус яамнаас дараах ажлыг зохион байгуулаад байна. Үүнд:
- Орон даяар “Залуучуудын хөгжилд хамтдаа” сарын аяныг зохион байгуулж, аяны хүрээнд аймгийн залуучуудын уулзалт хэлэлцүүлэг, спорт арга хэмжээ, залуучуудын төсөл байгуулах зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулсан бөгөөд нийтдээ 4000 гаруй залуучуудыг хамруулан зохион байгууллаа.
- Дээрх орон нутгийн уулзалт хэлэлцүүлгээс гарсан санал, зөвлөмжийг нэгтгэн орон нутгийн төлөөлөл, нийслэлийн залуучууд нийт 800 гаруй залуучуудын оролцоотой “Залуучуудын хөгжил-шинэчлэлийн бодлого, зорилт” үндэсний чуулганыг Соёлын төв өргөөнд 2013 оны 05 дугаар сарын 20-ны өдөр зохион байгууллаа. Залуучуудын хөгжлийн талаар хэрэгжүүлж буй бодлого, арга хэмжээний үр дүн,

тулгамдаж буй асуудлууд, тэдгээрийг шийдвэрлэх арга замын талаар хэлэлцээд, бүх аймаг, дүүрэгт зохион байгуулагдсан залуучуудын чуулганы үр дүнг үндэслэн, залуучуудын хөгжлийн талаар баримтлах шинэчлэлийн бодлого, зорилтуудын хүрээнд 18 асуудлаар бодлогын зөвлөмжийг баталсан.

- Залуучуудын хөгжлийн асуудлаар төрөөс хэрэгжүүлж буй арга хэмжээ, цаашид боловсруулах бодлогын баримт бичигт тусгах санал зөвлөмж боловсруулах зорилгоор НҮБ-ын Хүн амын сангийн дэмжлэгтэй залуучуудын асуудлаарх Бодлогын судалгааг хийж гүйцэтгэлээ.
- Мөн залуучуудын чиглэлээр хэрэгжүүлж буй бодлого арга хэмжээг анхан шатанд залуучуудад хүргэж ажилладаг нэгжүүд, орон нутгийн залуучуудын бодит байдалтай танилцах, дуу хоолойг нь бодлого, хөтөлбөр боловсруулахад тусгах зорилгоор бүсийн хэлэлцүүлгүүдийг үе шаттай зохион байгуулж байна. Энэ хүрээнд 2013 онд Хангайн бүсийн хэлэлцүүлгийг 6 аймгийн залуучуудын төлөөлөл, Төвийн бүс – 1 хэлэлцүүлгийг 3 аймгийн төлөөлөл бүхий 110 гаруй залуучууд албаны хүмүүсийг хамруулан зохион байгуулсан.
- Хүүхэд, залуучуудыг хөгжүүлэх, хүүхдийн хөгжлийг хангах зориулалтаар барьж байгуулсан барилга, байгууламжийн асуудлыг шийдүүлэх /ЗГҮАХ-159.1, 2013-2014/
- Хүүхэд, залуучуудыг хөгжүүлэх, хүүхдийн хөгжлийг хангах зориулалтаар барьж байгуулсан барилга, байгууламж, бий болгосон хөрөнгийн ашиглалтын өнөөгийн байдлын талаар мэдээлэл бэлтгэх, мэдээллийн сан бүрдүүлэх, дүн шинжилгээ хийх, санал дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2012 оны 10 сарын 17-ны өдрийн А/45 дугаар тушаалаар байгуулсан бөгөөд Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын дэд сайд Э.Тамираар ахлуулсан тус ажлын хэсэгт холбогдох төрийн болон төрийн бус албаны хүмүүс багтан ажилласан болно. Улмаар тус Ажлын хэсгийн санал, дүгнэлтийг үндэслэн Ерөнхий сайдын 2013 оны 01 сарын 31-ний өдрийн 27 дугаар захирамжаар өргөтгөсөн Ажлын хэсгийг ЗГХЭГ-ын дарга Ч.Сайханбилэгээр ахлуулан байгуулсан.

  Энэ хүрээнд Улаанбаатар хотод байдаг үйл ажиллагааны чиглэл нь зориулалтын бусаар ажиллаж байгаа буюу хувьчлагдсан гэх 13 барилга байгууламжийн судалгаа хийж, хөрөнгийг хуулийн хүрээнд хүүхдийн байгууллагын мэдэлд шилжүүлэх, менежментийг нь хүүхэд, залуучуудын хүсэл сонирхолд нийлүүлэх асуудлаар тодорхой санал, дүгнэлт боловсруулаад байгаа бөгөөд Хууль зүйн яамны зүгээс явуулж буй нэмэлт шалгалтыг дүнг эцэслэн гарсаны дараа Засгийн газарт танилцуулахаар төлөвлөн ажиллаж байна.

- Мэдлэг, чадвартай, хариуцлагатай, өөртөө итгэх зан үйл бүхий амьдралын ур чадвартай залуучуудыг төлөвшүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас Швейцарийн хөгжлийн агентлаг, Люксембургийн Засгийн газар, НҮБ-ын Хүн амын сангийн дэмжлэгтэйгээр хамтран хэрэгжүүлж буй “Залуучуудын хөгжил 2013-2017” төслийг хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд Залуучуудын хөгжлийн асуудлаарх үндэсний бодлого боловсруулж, хэрэгжүүлэх, бүтэц, тогтолцоог чадавхжуулах, залуучуудын хөгжлийн асуудлаарх нэгдсэн мэдээллийн сан, хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоо бий болгох, залуучуудын зан үйлийг өөрчлөх хөтөлбөр, стратеги боловсруулж, хэрэгжүүлэх, тэдний хөдөлмөрлөх, өөрийгөө хөгжүүлэх бүтээлч ухамсар, амьдралын зөв зан үйлийг төлөвшүүлэхэд чиглэсэн бүх төрлийн нөлөөллийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, Залуучуудын хөгжлийн төвийг зорилтот орон нутгуудад байгуулах зэрэг олон чухал бодлого, арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Төслийн хүрээнд 2013-2014 онд нийт 15 залуучуудын хөгжлийн төв байгуулах бөгөөд, үүнээс Дорнод, Дархан-Уул, Завхан аймгууд ЗХТ-ийг байгуулж, 12 төвийг 2014 оны 3-р улиралд албан ёсоор нээхэд бэлэн болоод байна.

Эдгээр төвүүдийг байгуулснаар орон нутгийн залуучууд маань чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, хэрэгцээтэй мэдээ мэдээлэл, мөн сургалт, зөвлөгөөг авах боломжтой юм.
Мөн төслийн хүрээнд хэрэгжүүлэх томоохон ажлын нэг өсвөр насныхны үе тэнгийн сургаг багш нарын бэлтгэх, залуучуудын өөрсдийх нь оролцоог хангах үүднээс залуучуудын зөвлөлийг байгуулан өсвөр үе, залуучуудад чиглэсэн амьдрах ухааны болон эерэг харилцаа, хандлагын сургалт нөлөөллийн ажлыг үе шаттайгаар зохион байгуулах юм.

- Хүний хөгжлийн түвшинг үндэсний хэмжээнд цогц судалгаа, шинжилгээний хүрээнд тодорхойлсон томоохон баримт бичиг бол тухайн улс орнуудын Хүний хөгжлийн илтгэл байдаг билээ. 1997 оноос эхлэн нийт 5 удаа боловсруулж, үндэсний болон олон улсын хэмжээнд танилцуулсан Монгол Улсын Хүний хөгжлийн 6 дахь удаагийн илтгэлийг “Залгамж үеийнхээ төлөө: монгол улсын хөгжилд залуучуудын оролцоо“ сэдвээр боловсруулах ба ингэснээр бид бүхэнд Монголын залуучуудын хөгжлийн өнөөгийн нөхцөл байдлыг бодитойгоор тодорхойлох, үнэлэх, улмаар нотолгоонд суурилсан бодлого боловсруулах боломж бүрдэх юм.
- Залуучуудын асуудлаар 2014 онд илтгэн гаргах хүний хөгжлийн ээлжит илтгэлийг удирдах Үндэсний хорооны бүрэлдэхүүнийг ХАХНХ-ын сайдын 2013 оны А/124-р тушаалаар батлан ажиллаж байна. Мөн илтгэлийг боловсруулахад мэргэжлийн үүднээс гол зөвлөмж, зөвлөгөө өгөх чиг үүрэг бүхий Зөвлөлдөх хороо 22 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдан ажиллаж байна.
- Үндэсний хүний хөгжлийн илтгэлийг боловсруулах хүрээнд Залуучуудын асуудлаарх төр засгийн бодлого хөтөлбөрүүдэд хийх дүн шинжилгээ, Тусгай хэрэгцээ шаардлагатай хүн амын бүлэг (эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ЛГБТ), Боловсрол, Залуучуудын эрүүл мэнд, эрүүл аж төрөх асуудлаар, залуучуудын хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн зах зээлийн төлөв байдал, аж ахуй бизнес эрхлэлт, ардчиллын талаарх залуучуудын үзэл бодол, улс төрийн идэвх оролцоо зэрэг сэдвүүдийн хүрээнд 5 цогц судалгааг мэргэжлийн судлаачдыг сонгон шалгаруулан гүйцэтгэн, судалгааг эцэслэх ажлыг зохион байгуулж байна. Энэ хүрээнд судалгаанд хамрагдаж буй залуучуудын хамрах хүрээ, насны ангилал болоод залуучуудын хөгжилд урлаг, спортын гүйцэтгэх үүрэг, “Гэр” хорооллын залуучуудын нөхцөл байдлын тухай, Залуучуудын чиглэлээр үйл ажиллагаа хэрэгжүүлдэг иргэний нийгмийн байгууллагуудын тухай, Ардчиллын тухай залуучуудын үзэл бодол, нийгмийн мэдээллийн хэрэгслийн ашиглалт, хэрэглээ асуудлууд судалгааны үр дүнд харагдах юм.
  “Залгамж үеийнхээ төлөө: монгол улсын хөгжилд залуучуудын оролцоо” сэдэвт 6 дахь илтгэлийг 2014 онд эцэслэн боловсруулахаар ажиллаж байна.

- Залуучуудын хөгжлийн асуудлаар бодлого боловсруулах, үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх хүрээнд салбар дундын уялдаа холбоог шат шатанд нь хангаж ажиллах үүднээс яамдууд залуучуудын асуудлыг хавсран хариуцах мэргэжилтнүүдийг яамдын Төрийн нарийн бичгийн дарга нараар нь томилуулан ХАХНХЯ-ны харьяа агентлагуудын холбогдох мэргэжилтнүүдийн хамт улирал бүр мэдээлэл солилцох уулзалтыг 2013 оны 1-р улирлаас эхлэн зохион байгуулж байна.